


ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ГҮЙЦЭТГЭЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧИД ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ ХАНГАХ НЬ



Ю.ОЮУНАА

Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш, ахлах
дэслэгч

Товч агуулга: Дотоод хэргийн их сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн төгсөгчдийг шийдвэр гүйцэтгэгчээр томилон ажиллуулах шаардлагатай байгааг онцолсон.

Abstract: The paper emphasizes that graduates from the School of Court Decision Execution Service in the University of Internal Affairs should be appointed as bailiffs.

Түлхүүр үг: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангасан боловсон хүчин, шийдвэр гүйцэтгэгч

Key words: personnel meets with demands and requirements by Execution Agency of Court decision, bailiff

Улс төр, нийгэм эдийн засгийн шинэчлэлийн үр дүнд иргэд хоорондын эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус гэрээ хэлцэл нэмэгдэж, үүнтэй холбоотой иргэний хэргийн зөрчил маргаан, шийдвэр гүйцэтгэлийн ажлын ачаалал, шийдвэр гүйцэтгэгчийн эрэлт хэрэгцээ жил ирэх тусам өсөх хандлагатай байгаа юм.

Түүнчилэн эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлтэй уялдан ялын бодлогод зарчмын шинжтэй өөрчлөлт орсноор гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хорих ял оноох бус хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оноож, гэмт этгээдийг нийгмийн орчинд нь өөрчлөн засахад /нийгэмшүүлэх/ ихээхэн анхаарч байгаатай уялдуулан шүүхээр ял шийтгүүлэгчдээс хорих ял эдлэгсдийн тоо буурч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлэгчдийн тоо өсөх хандлагатай байна. Үүнтэй холбоотойгоор хорихоос өөр төрлийн ял

эдлүүлэх ажиллагаа хариуцсан шийдвэр гүйцэтгэгчийн орон тоо ч нэмэгдсээр байгаа юм.

Тухайн нөхцөл байдалтай уялдуулан шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийн чадавхийг чиглүүлэхэд Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулиас анхаарч сургалтын хөтөлбөр агуулгадаа өөрчлөлт хийх замаар сургалтын үйл ажиллагаагаа боловсронгуй болгосоор ирсэн бөгөөд өнөөдрийн байдлаар захиалагч байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцсэн 1200 гаруй алба хаагчийг төгсгөсөн байна¹. Төгсөгчид шийдвэр гүйцэтгэгч, ээлжийн дарга, ерөнхий жижүүр, хоригдлын тоо бүртгэлийн байцаагч, нийгмийн ажилтан, төлөөлөгч, дэглэм, харуул хамгаалалтын байцаагч, сэтгэл зүйч гэсэн албан тушаалуудад томилогдон ажиллаж байна.

Гэсэн хэдий ч Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 211 дүгээр тушаалаар “Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам” батлагдаж тухайн сонгон шалгаруулалтанд энгийн хууль зүйн их, дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн төгсөгчдийг сонгон шалгаруулалтанд оролцуулж тэнцсэн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгчээр томилогдон ажиллах боломжийг бүрдүүлсэн².

Журам хэрэгжиж эхэлснээр сонгон шалгаруулалтанд тэнцсэн эрх зүйчид иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэгч болон эрүүгийн шийдвэр гүйцэтгэгчээр томилогдон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжийн хүрээнд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Шийдвэр гүйцэтгэгчдийг гүйцэтгэж буй чиг үүргийг онцлогоос хамаарч хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллаж буй шийдвэр гүйцэтгэгчид нь нийт алба хаагчдын 9.1 хувийг эзэлж байгаа юм.

Тодруулбал улсын хэмжээнд нийт эрүүгийн, иргэний, захиргааны, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хариуцсан 284 шийдвэр гүйцэтгэгч, 55 ахлах шийдвэр гүйцэтгэгч ажиллаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/125 тушаалаар батлагдсан “Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах журам”-ын **“Хууль сахиулахын их сургуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-хууль сахиулах ажил хөтөлбөрөөр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн**

¹ Магадлан итгэмжлэхийн тайлан. ДХИС. 2018 он

² Хууль зүй дотоод хэргийн сайдын 2010 оны 211 дүгээр тушаал

иргэний төгсөлтийн шалгалтын үнэлгээг шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтын шалгалтын үнэлгээтэй адилтган үзнэ” гэж заасан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн төгсөгчдөд шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах боломжийг бүрдүүлсэн³.

Тухайн журам хэрэгжиж эхэлснээр тус сургуулийн төгсөгч нь бусад их, дээд сургуулийг эрх зүйн мэргэжлээр төгссөн төгсөгчидтэй адил шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад орж шалгалт өгөх шаардлагагүй болсноор 2017 онд уг сургуулийн төгссөн төгсөгчид шийдвэр гүйцэтгэгчээр томилогдон ажилласан байдаг. Үүнээс хойш жил бүрийн төгсөгчдөөс шийдвэр гүйцэтгэгчээр томилогдон ажиллахыг эрэлхийлэх болсоор байгаа билээ.

Харин улсын хэмжээнд ажиллаж байгаа шийдвэр гүйцэтгэгчдийн 29,0 хувийг Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн төгсөгчид эзэлж байгаа юм.

2017 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар шийдвэр гүйцэтгэгч нь цэргийн цол хэрэглэхээр хуульчилсан бөгөөд уг хуулийн 270 дугаар зүйлийн 270.3 дахь хэсэгт “Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын алба хаагчаар Төрийн албаны тухай болон холбогдох бусад хуульд заасан шаардлага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тогтоосон журам, эрүүл мэнд, бие бялдар, мэргэжил, ёс зүйн шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан, арван найман насанд хүрсэн, дээд боловсролтой, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байгаагүй Монгол Улсын иргэнийг авч ажиллуулна” гэж заасан⁴.

Дээрх шаардлага нь шийдвэр гүйцэтгэгчээр ажиллах боловсон хүчин нь цэргийн хэргийн эрдэмд суралцсан, биеийн болон сэтгэлийн тэвчээр, хатуужлийг эзэмшсэн, ажлын ачаалал даах чадвартай, шүүхийн шийдвэр гүйцэтгэх салбар эрх зүйн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн эзэмшсэн байх шаардлагатайг харуулж байна.

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх сургуулийг сонгон элсэж буй сонсогчид тухайн мэргэжлийг эзэмших чин хүсэлтэй байдгаас гадна тус мэргэжлийг эзэмшихийн тулд шалгуур шаардлагыг сургалтын 4 жилийн хугацаанд даван туулдаг бөгөөд энэхүү сорилт бэрхшээл нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон

³ Хууль зүй дотоод хэргийн сайдын 2017 оны 08 дугаар сарын 31-ний А/125 дугаар тушаал

⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.//Төрийн мэдээлэл. 2017 он

эзэмшсэн мэргэжлээрээ бахархах бахархлыг төрүүлж Монгол Улсын төлөө бие, сэтгэлээ бүрэн зориулах эрмэлзлэлийг бий болгодог юм.

Дотоод хэргийн их сургуулийн сургалтын үйл ажиллагааны давуу талууд нь сонсогч оюутнуудыг тус сургуульд элссэн цаг хугацаанаас эхлэн цэргийн хэрэг, тэсвэр, хатуужил, ёс зүйн сургалтыг явуулах бөгөөд элсэгч нь сонгосон мэргэжлийнхээ талаар мэдлэгтэй болохоос гадна сонголтоо өөрчлөх боломжийг олгодог. Түүнчилэн үйлдвэрлэл, практик, клиникийн сургалтыг үр дүнтэй явуулах үүднээс сургалтын түшиц газар, клиникийн төвөөр ШШГЕГ-ын харьяа хорих анги, алба нэгжийг сонгон ажилладаг.

Түүнээс гадна сонсогчид сургалтын сүүлийн 2 жилийн хугацаанд буюу 3,4 дүгээр курсдээ мэргэжлийн хичээлүүдийг судалдагаараа давуу талтай юм.

Энэ нь сонсогч оюутан эхнээсээ ямар байгууллагад ажиллахаа мэдэж түүний төлөө суралцаж байдгаараа онцлогтой.

Тус сургуулийг төгсөгчид шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлэхдээ бусад хууль зүйн их, дээд сургууль төгссөн шийдвэр гүйцэтгэгчдээс давуу болон сул талыг судлах зорилгоор удирдах ажилтнуудтай хийсэн ярилцлагын хүрээнд “Цэргийн хэргийн мэдлэг сайтай, цэргийн дүрэмт хувцасыг зохих журмын дагуу өмсөж хэрэглэдэг, хувийн зохион байгуулалт өндөр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай хийж гүйцэтгэдэг, ажлын бүтээмж сайтай, төрийн албан хаагчийн харилцааны ёс зүй, ур чадварыг эзэмшсэн, иргэдийн зүгээс өргөдөл гомдол гаргуулдаггүй, гаргасан өргөдөл гомдлыг богино хугацаанд шийдвэрлэж хариуг өгдөгөөрөө аливаа асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх, хатуу үг даах чадвартай гэсэн бол сул тал нь үг дуу цөөтэй” гэж дүгнэсэн байдаг.

Үүнээс гадна сүүлийн жилүүдэд тус сургуулийн төгсөгчид нь шийдвэр гүйцэтгэгчээр томилогдон ажилласан үеэс богино хугацаанд албан тушаал дэвших, улсын болон байгууллагын “Шилдэг шийдвэр гүйцэтгэгч”, “Шилдэг ажилтан”-аар шалгарч хамт олноо үлгэрлэн манлайлсаар байгаа юм.

Эндээс дүгнэхэд Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн сургалтын бодлого нь үр дүнд суурилсан сургалтын тогтолцоог нэвтрүүлэх, захиалагч байгууллага /ШШГЕГ/-ын хэрэгцээ, шаардлагад нийцсэн боловсон хүчнийг бэлтгэж байгааг харуулж байна.

Иймээс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас шийдвэр

гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалт зохион байгуулж, зөвхөн мэдлэг сорих шалгалтын хүрээнд боловсон хүчнээ сонгож авч дараа нь тухайн мэргэжилтэндээ цэргийн хэргийн мэдлэгийг олгох, тэвчээр хатуужилд сургах гээд цаг хугацаа зарсан олон ажлыг хрэгжүүлдэг ч төдийлөн үр дүнтэй байдаггүй нь практикаас харагдаж байдаг. Иймээс тухайн албан тушаалд магадлан итгэмжлэгдсэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-Эрх зүй” хөтөлбөрийн хүрээнд дээрх мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн эзэмшсэн боловсон хүчнийг шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаалд голчлон томилж ажиллуулах нь зүйтэй гэж судлаачийн хувьд дүгнэж байна.

Мөн 1+1 буюу дээд боловсролтой иргэдийг шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр мэргэшүүлж төгсгөх боломжийг эрэлхийлж байна. Тухайн хөтөлбөр хэрэгжиж эхэлвэл иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах мэргэжлийн түвшний төлөөлөл болж төлөвших боломжтой гэж үзэж байна.